

ДАРХАД АРДЫН ДУУНЫ ХЭЛ НАЙРУУЛГЫН ОНЦЛОГ

Д. Батжаргал*

Дуу бол сэтгэлийн жигүүр. Нутгаасаа алс хол явж байгаа хүмүүс харь оронд амьдарч байгаа хэнбугай ч гэсэн “Далийн цэцэг ягаараа л, дассан нутаг санагдаа л... сурнагийн цэцэг ягаараа л, сурсан нутаг санагдаа л...” гэдэг эхний бадаг сонсуутхүний сэтгэл уярмаар. Нутаг нутгийн дуу болгонд ийм ид, хүний сэтгэлийг соронзон мэт татах увидас хүч шингэсэн байгаа.

Дархад дууг эмхэтгэн цуглуулсан К.Н.Яцковская “Сто песен дархата Г.Давааджия”, нутгийн уугуул И.Ламжав, Д.Пүрэвдорж, Н.Цэгмид, С.Аюурзана, МУГЖ, дуучин Б.Дариймаа, Бельгийн судлаач Лаурент Леграйн /Laurent Legrain/ нарын эмхэтгэл бүтээлүүдээс үзэхэд хэл найруулгын хэд хэдэн онцлог харагдаж байна. Үүнд, юуны өмнө **байгалийн үзэгдэл, хувирал өөрчлөлтийг хүний сэтгэлийн дотоод ертөнцтэй гайхалтай холбож үзүүлсэн** байна. Сэтгэлийн хямралыг салхи шуурга, униар манан, бороо цас, буцах улирлын төрх байдалтай харьцуулан үзүүлсэн нь нэн олон. Жишээ нь,

*Зөөлөнгийн арын мод нь
Зөрөлдөн шуурч л байна даа
Зөөлөн бор л царай нь
Хувиран тусч байна даа,*

Уулын модод зүгээр ч нэг найгаагүй. Асар их хүчтэй шуурганд зөрөлдөн, наана цаанаа орон байх мэт. Наад захын ухаанаар бодвол модод салхины аясаар нэг л зүгт найгамаар. Гэтэл зөрөлдөн гэдэг үг нэн хүчтэй илэрхийлэл болж байна. Энэ дууны үүх түүхийг талаар Д.Пүрэвдорж “Дархадын нэртэй буюу домогт дуунууд” номдоо “Олоон жилийн өмнө сэрүүн Хөгөөр нутаглдаг Дожоо гэж ид дунд насны эр амьдарч байжээ. Тэрээр авгай аваагүй явсаар нас ахисан хойноо Рэнчинлхүмбэ сумын төвд байдаг нэгэн бүсгүйтэй танилцаж, түүнд сэтгэлтэй болон Хөгийн гол, Лхүмбийн төв хоёрын хооронд дурлал хайрын нэгэн жим гарсан байна. Тэр үед Дожоо нь багийн даргын алба хашиж байжээ. Багийн дарга бүсгүйд сэтгэлтэй болсноос хойш сумын төв үрүү байнга явах болж, гэгэлзсэн аятай дууг өөрөө зохион дуулах болсон”¹ нь дээрх дуу юм. Хоёрдугаар бадагтаа,

*Товгын арын мод нь
Торолзон шуурч л байгаа даа*

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Утга зохиолын тэнхим

¹) Пүрэвдорж Д (1998), “Дархадын нэртэй буюу домогт дуунууд”, 36-37-р тал.

Тогтуун цайвар царай нь

Тодрон тусч л байгаа даагэж дуулдаг байжээ. Багийн даргын сэтгэлтэй болсон хүүхэн нь насаар бага байсан боловч тэр хоёрын хайр сэтгэл насны зөрүүд боогдсонгүй ханилан сууцгаажээ. Насны зөрүүтэй болохоор сэтгэлийн хөдлөлөө хүчтэй шуургатай харьцуулан дүрсэлж моддын хөдөлгөөнийг “зөрөлдөн”, “торолзон” гэдэг үгээр илэрхийлжээ.

Дархад ардын дуунд **үг сонголт нэн оновчтой** байдаг. Энэ талаар дархад дуугаа дуулж нутгийн зон олон төдийгүй улс Монголдоо “Дархад дууны Дариймаа” хэмээн нэрлэгдсэн Монгол улсын гавьяат жүжигчин Б.Дариймаа “Дархад ардын дууны гайхам өв сан” номдоо “Дархад ардын дууны авсаархан хэллэг, гүн утга санаа, уянгалаг аялгуу нь тун өвөрмөц билээ. Дархад дууны үг нь маш уран цэцэн хэллэгтэй, аливаа юмны голыг олсон хурц тод дүрслэлтэй байдаг онцлогтой. Жишээ нь,

“Харганээн толгой хүрэнтээл

Хариогүэ намар л болох нь ёо

Харих л шувуо нь ганганаал

Хатан намар болох нь ёо” гэж намар болж байгааг ингэж нүдэнд харагдаж, чихэнд сонсогдохоор уран сайхан дүрслэн хэлсэн үгтэй дуу олоход бэрх дээ”² гэж бичсэн байна. Энэ номд оруулсан бүх дуугаа дархад аялга, дуудлагаар бичжээ. Түүнийг орчин цагийн монгол хэлээр бичвэл,

Харганын толгой хүрэнтээ л

Хариугүй намар болох нь ээ

Харих л шувуу ганганаал

Хатан намар болох нь ээ гэж нэг ч их өөрчлөлтгүй бууж байна. Энэ дуунд хүрэнтэж байгаа харганын толгой, ганганаж байгаа усны шувууд уйтгарт намрын хөг аясыг олон үггүй харуулж байна. Ерөөс дархад дуунд сэтгэл санааг илэрхийлсэн “Тайгын оройгоор будраад”, “Тамхи татаж маанайгаад”, “Алсын оройгоор будраад”, “Архи л ууж маанайгаад” гэх мэт хүчтэй дүрсэлсэн шүүмжилсэн санаа элбэг бий. Бударч байгаа уулсын оройгоос илүү, маанайж донгиотсон хүний явдал нь сэтгэл эмзэглүүлж байна. Дууныхаа бүхэл бүтэн утгыг тээж яваа “маанайгаад”, “будраад” гэдэг үгс үнэ цэнэтэйг харуулж байна.

Дархдууд дууныхаа ганц үгийг ямар их хайрладгийг эрдэмтэн судлаач Л.Хүрэлбаатарын бүтээлээс харж болно. “Дуун утгын яруу зохист” номондоо “Найр дээрээсээ, наадам дороосоо” гэгчээр найр толгойлох маягтай байсан Ойдов гуай, Жамба гуайн хүүхдүүдээс нэгийг нь “Дуул” гэсэнд гэрийн хаяа уруу сууж байсан нэг бор хүү хулгаж ядаж байснаа ингэж дуулав.

Далайн захын ногооноос

Идэж л сурсан морь юм

Даавуу майхны хойморт

Унтаж л сурсан Тоня

Ээжсийн захын ногооноос

Идэж л сурсан морь юм

Эсгий гэрийн хойморт

Унтаж л сурсан Тоня

²⁾ Дариймаа Б (2008), “Дархад ардын дууны гайхам өв сан”, 11-р тал.

гэж дуулсанд Лувсдай гуай, хоймроос “Та нар дууны үгийг зөв хэлж дуулж бай” гээд “Идэж л сурсан морь юм” гэдгийг “Идэж л сурсан морь маань”, “Унтаж л сурсан Тоня” гэдгийг “Унтаж л сурсан Тоня гуай” гэж засаад “...морь юм” гэхэд ая нь үгэндээ багтаж байна уу? Тэгвэл “...морь маань” гээд аялаад үз. Тэгж түгжигдэх юм байхгүй, урт сайхан болоод ирж байгаа биз. Түүнтэй адил “Унтаж л сурсан Тоня” гэхлээраялахад ч, ухахад ч ямар байна. “...Тоня гуай” гэхлээр аялахад ч эвтэйхэн болоод, тэр “гуай” гэдэг үгнээс хэн нэгэн Тоня биш, тэр нэгэн, тийм нэгэн Тоня гэдэг нь танигдаж ирж байгаа биз дээ” гэснээ, “Бас энэ үгнээс цааш олон бадаг бий шүү дээ. Та нар ингэж дуулсаар мартагдаж байна” гэж хэлснээ,

*Бургааст, Бунхант гэдэг нь
Буудаг нутгийн нь нэг л дээ
Бухандай дэлтэй саарал нь
Унадаг морины нь нэг л дээ
Ардаг Бунхант гэдэг нь
Суудаг нутгийн нэг л дээ
Аржгар дэлтэй шаргал нь
Унадаг морины нь нэг л дээ
Ээжийн зах нь мэлтэлзээ л
Эмнэг борлог дүүхэлзээ л
Далайн зах нь мэлтэлзээ л
Дааган борлог дүүхэлзээ л
Хэрэвсдэг хангайн бараа нь
Хэргэлтэн шуурч л байгаа даа
Хэлсдэгийн маань санаа нь
Наашаа татаж л суугаа даа*

гээд л олон бадгийг урсгаж алдав. Тэгэн байсаар архинд баахан халсан улс, Жамба гуайн том хар хүү, 26 настай Баттогтохыг “Дуул, дуул” гэж шалсаар байгаад дуулуулсанд “Байз, байз” гэдэг шог аястай, сургаалийн их нарийн санаатай сонин дууг дуулаад дуустал, Лувсдай гуай хоймроос бас шүүмжлэв. Чи “Эгч дүүгийн хооронд эвгүй харьцнав, байз байз” гэж юу хэлнэв? “Эвгүй харьцнав” гэдэг олонхийн хэлэлцэх дуртай болсон этгээд сольчир үг тэр дуунд чинь байхгүй. “Эвгүй хэлнүүт” гэхгүй юу. Бас “Хар л хээр л моринд нь хазаараа тавинав, байз, байз” гэж юу хэлж байгаа юм? “Хазаараа хийх” гэхээс “хазаараа тавих” гэдэг юм уу?³ хэмээн Л.Хүрэлбаатар доктор бичжээ. Дархадын ухаант өвгөд дуундаа ямар хайртай, дууны үгэнд ямар соргог хандлагийг харуулах үүднээс Л.Хүрэлбаатар докторын бичсэн “Дархадын аман билиг”-ээс дэлгэрэнгүй орууллаа.

Дархад дуунд “хоё”, “гэмбэ”, “додгаа”, “маань”, “эвий минь”, зэрэг **хандсан үг маш элбэг** нь нэг чухал онцлог. Энэ нь монгол түмэн тэр дундаа дархад зоны зочломтгой, найрсаг зан хандлагатай холбоотой. Дархдууд яриандаа “додгаа” /хүүхээ гэсэнтэй төстэй үг/, “бичгэн” /бяцхан гэсэн утгатай. Ихэвчлэн хүүхэд багачуудыг бичгэн гэж дуудна/ “аа хоё” /найзаа гэсэн санаатай дотнотчилсон үг/ гэсэн үгийг маш их оруулж ярьдаг.

*Аа, хоё, иш дээ, зайлуул даа
Хүрэн жинстэй ноёдууд нь
Хүрээгээ хаяад талийлаа
Хөгшин, залуу бүгдээрээ*

³⁾ Хүрэлбаатар Л (2005), “Дуун утгын яруу зохист”, 96-98-р тал.

*Хөөгдөн туугдан талийлаа
Хэргэм цолтой ноёдууд нь
Хийдээ хаяад талийлаа
Хүүдий хүүдий мөнгөнөөсөө
Хагацаж ядан талийлаа*

Үе тэнгийн хоёр хөгшин цайгаа хувааж уунгаа хуучилж байгаа мэт санагдаж байна уу. Дагестаны ардын яруу найрагч Расул Гамзатов “Хамгийн сайн ваарыг жирийн шавраар хийдэг. Хамгийн сайн шүлгийг энгийн үгээр бичдэг” гэж хэлсэн байдаг. Хөрөнгө мөнгөөрөө гайхуулж байсан ноёд түшмэд хэрэгтэй цагаа болохоор хамаг бүхнээ хаяж оддогийг сануулаад байгаа нь цаанаа “Иш дээ, эд нар чинь хуурамч юм шүү” гэдгийг хэлээд байна. Бидний том гэж боддог ихэс дээдэс, ноёд түшмэд заримдаа, бидэнтэй адилхан, заримдаа биднээс долоон дор амьтад байдаг юм гэдгийг сануулсан утга нь тод мэдрэгдэж байна. Ерөөс ардын дуу, тэр дундаа **дархад дуу ардын хэлэнд ойр дөт байдаг**. Үүнийг тэрлэгч өмнө нь бичсэн “Ардын дүрслэлийн хэл” өгүүлэлдээ, цэцэн билигт дархад түмний Чанцалдулам хэмээх нэгэн эмэгтэй хэдийгээр ядуу татуухан амьдралтай тэнэмэл нэгэн байсан ч залуу насны хайр дурлалаас тойрсонгүй. Хүнд хайртай болж, түүндээ зориулан,

*Хээтэй цоохор домбыг нь
Сөгнөн суухын аврал
Хэттэй бэлтэй ташааг нь
Түшин суухын аврал
Хорол тоонотой өргөөндөө
Хоёулаа суухын аврал
Хотгор цоохор сарлагийг нь
Хотолж л явахын аврал гэж нэгэн үе дуулж байсан бол дараа нь,
Домбын чинээ Донхжий нь
Дотроос гарахаа болилоо
Ханцуйн чинээ Донхжий нь
Хайраас гарахаа байлаа
Угжийн чинээ Донхжий нь
Ухаанаас салахаа болилоо*

хэмээсэн нь Донхжий гэдэг хүнд хайртай болж, сэтгэлийн шаналал эдлэн түүнээ хүсэж мөрөөдөж явахдаа ийм дуу зохиожээ.

Энд ардын дүрслэлийн олон сайхан жишээ харагдана. Сархад айргийг сөгнөдөг байтал домботой цай хүртэл аз жаргалын амт баланд согтуурдгийг энгийн хэлээр дүрслэн, хайртай болсон хүнээ хамгийн ойр дөт зүйлээр төлөөлүүлсэн нь ганган чамин бус атлаа эерүү зөөлөн дулаан зүйрлэл болжээ. Энд зохиогчийн олон хүсэл мөрөөдөл шингэж, “хот дүүрэн сарлаг”, “хорол тоонотой гэр”, “хэттэй бэлтэй ташаа” гээд мал сүрэг, гэр орон, хань ижил гээд дутуу гуцуу зүйлгүйгээр дүрслэн илэрхийлсэн байна. Судлаачдын тэмдэглэсэнээр дархад дуу 700 гаруй байдаг гэсэн мэдээ бий. Тэдний дотроос ардын яруу сайхан хэлийг шүүрдвэл мөн ч баялаг сайхан үгс гарахсан.

Монгол ардын аман зохиол дүрслэх яруу хэрэглүүрээр үлэмж баян тансаг байдаг. Энэ нь нутаг нутгийн ардын дуунд өнгө төрхөө олж хэлбэржсэн байдаг. Доктор Д.Туяа “Дархад ардын дууны шүлгийн онцлог” /2004/ илтгэлдээ дархад ардын дуу дүрслэх яруу хэрэглүүрээр баялаг байгааг уран хэтрүүлэл, егөөдөл, амьдчилал,

зүйрлэл, адилтгал, төлөөлөл, чимэг үг зэргээр жишээ авч тайлбарласан байна. “Аливаа юмны онцлог тал, чанар, шинжийг гойд товойлгох зорилгоор үнэн байдалд байдгаас нь хэт их болгох чиглэлээр үгийн утгыг шилжүүлэн хэрэглэх ихэсгэсэн хэтрүүлэл байна. Тухайлбал: “Алдаж яваагүй толгой” дуунд будан мананг уран хэтрүүлэг хэрэглэн огторгуйд тулсан гэж ихэсгэснээр өөрийгөө хэр баргийн юманд торохгүй мундаг хүн гэдгээ хэлэхийг зорьсон байна.

Огторгуйд тулсан буданд нь

Төөрч л яваагүй толгой

Онцолж харсан ганцыгаа

Алдаж яваагээ толгой

Үгийг эсрэг утгаар нь хэрэглэн, санаагаа илтгэж, уран дүрслэн яруу илтгэх адилтгасан егөөдөл байна. Тухайлбал: “Баримал сууна уу, татгай минь” дуунд

Батаа даргын өргөөнд нь

Баримал сууна уу, татгай минь

гэсэн мөрөнд айлд ирсэн гийчнийг үл тоомсорлон, мэндийн хариу өгөөгүй эхнэрийг егөөдөж хүн биш баримал, үзэсгэлэнгийн амьгүй юм байна уу даа гэж амьтай зүйлийг амьгүйчлэн егөөджээ⁴. Мөн

Арвин шаргалын айраг нь

Аяга дүүрэн хэмжээтэй

Ахар панзын авгай нь

Арван гүрлээ(сүлжээ) гишгэдэлтэй

Энд “гүрлээ” нутгийн аялгууны үгийг гээгний сүлжээ гэсэн утгаар хэрэглэсэн байна. Тэгэхээр хүний алхааг гээгний сүлжээгээр авсан нь шинэлэг сайхан шигтгээ адилтгал болжээ. Ийм жишээг олонтаа олж болно.

Эцэст нь тэмдэглэхэд дархад ардын дуу нь хэл найруулгын хувьд доорхи хэдэн онцлогтой байна. Үүнд,

- байгалийн үзэгдэл, хувирал өөрчлөлтийг хүний сэтгэлийн дотоод ертөнцтэй гайхалтай холбож үзүүлсэн,
- үг сонголт нэн оновчтой
- хандсан үг олонтой
- дүрслэх яруу хэрэглүүр ихтэй
- ардын ярианы хэлэнд ойр дөт
- харилцаа ихтэй зэрэг болно.

Нутаг нутгийн ардын дууг задлан судлах тусам орчин цагийн монгол хэлэнд хэрэглэгдэхгүй болсон сайхан найруулга, дуу чимээний дүрслэл, үйл хөдөлгөөний илэрхийлэл зэрэг нь олон байна.

⁴) Туяа Д (2004), “Дархад дууны шүлгийн онцлог” илтгэл Мөрөн.

НОМ ЗҮЙ

1. Дариймаа Б. (2008), “Дархад ардын дууны гайхам өв сан”, Улаанбаатар.
2. Пүрэвдорж Д. (1998), “Дархадын нэртэй буюу домогт дуунууд”, Мөрөн.
3. Туяа Д. (2004), “Дархад дууны шүлгийн онцлог” илтгэл Мөрөн.
4. Хүрэлбаатар Л. (2005), “Дуун утгын яруу зохист”, Улаанбаатар.

РЕЗЮМЕ

Дархадские народные песни в стилистическом отношении имеют следующие особенности: А именно,

- Блестящее соотношение природного явления и его эволюции, изменения с внутренним душевным миром человека;
- Точный подбор слов,
- Обилие слов обращения
- Обилие благозвучных предметов изображения
- Близость к народному разговорному языку
- Множество песен диалог